# БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН КОПИА-МОНГОЛ ТӨВИЙН САНХҮҮЖИЛТЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН БУУДАЙН ЭЛИТ ҮР ГАРГАХ, ҮРЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(Төслийн эцсийн байдлаар)

2016 оны 3 дугаар сарын 30-ны өдөр

| № | Хөтөлбөр / төслийн агуулга | Гүйцэтгэл |
|---|---|---|
| 1 | Монгол улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа ХААҮШУОНТ болон Бүгд найрамдах Солонгос улсын Копиа-Монгол төвийн хооронд Буудайн элит үр гаргах, үр үржүүлэх төсөл хэрэгжүүлэх тухай санамж бичиг, 2013 оны 12 дугаар сарын 18, 23-ны өдөр. | Төслийн зорилго: Буудайн элит үр гаргах, шинэ сорт бүтээх |
| 2 | Санхүүжилтийн эх үүсвэр | Буцалтгүй тусламж |
| 3 | Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих хугацаа | Гол хэрэгжүүлэгч байгууллага : КОПИА-МОНГОЛ ТӨВ / 2014.05.15 ~2017.05.14<br>Хамтран хэрэгжүүлэгч байгууллага : Ургамал газар тариалангийн хүрээлэн |
| 4 | Төслийн зорилтууд | • Монгол оронд нутагшсан буудайн сортуудын элит үр гаргах / эрт болцтой Дархан 131, дунд болцтой Дархан 34, Арвин /Дархан 166 /, дунд орой болцтой Дархан 144/<br>- Үрийн эх материал сонгох<br>- Анхдагч үрийн аж ахуй<br>- Элит үр үйлдвэрлэх<br>• Буудайн арвин ургацтай, биохими технологийн чанар сайтай ган болон өвчинд тэсвэртэй селекцийн эх материал бий болгох<br>- Солонгос болон Монгол орны буудайн сорт дээж солилцох, сорих, селекцид ашиглах<br>- Буудайн чанар, ган, халуун тэсвэрийг сайжруулах селекцийн ажил эхлүүлэх<br>- Буудайн селекцийн дугааруудад ургац, чанар, ган, халуун, өвчин тэсвэрийн үнэлгээ өгөх, шалгаруулах |

**5. Зардал**

Төсөв (нийт шаардагдах зардал) -165000 ам доллар

| Үүнд : | Төсөв | | | | Гүйцэтгэл | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2014 | 2015 | 2016 | Нийт | 2014 | 2015 | 2016 | Нийт | Хувь |
| Үйл ажиллагааны зардал | 45.4 | 28.0 | 29.0 | 102.4 | 43.4 | 28.6 | 29,0 | 101.0 | 98.6 |
| Материалын зардал | 11.2 | 4.5 | 3.5 | 19.2 | 11.2 | 4.0 | 3.5 | 18.7 | 97.3 |
| Цалин томилолтын зардал | 12.5 | 9.8 | 9.8 | 32.1 | 14.5 | 9.8 | 9.8 | 34.1 | 106,2 |
| Бусад зардал | 5.9 | 2.7 | 2.7 | 11.3 | 5.9 | 2.6 | 2.7 | 11.2 | 99.1 |
| Нийт зардал | 75 | 45 | 45 | 165 | 75 | 45 | 45 | 165 | 101.3 |

**6. Төсөл, хөтөлбөрийн зорилт :**

| Зорилт | Гүйцэтгэл |
|---|---|
| Монгол оронд нутагшсан буудайн сортуудын элит үр гаргах /эрт болцтой Дархан 131, дунд болцтой Дархан 34, Арвин /Дархан 166 /, дунд орой болцтой Дархан 144/<br>1-р зорилтын хүрээнд : | Судалгаа явуулсан 3 жилд буудайн эрт болцтой Дархан-131, дунд болцтой Арвин /Дархан-166/, Дархан-34, дунд орой болцтой Дархан-144 сортуудын үр үржүүлгийн ажлуудыг хийжээ.<br><br>*<u>Эх материалын сонголт</u>*<br>– Эх материалын сонголтыг ганцаарчилсан болон бөөний сонголтын аргаар хийж гүйцэтгэлээ. Ганцаарчилсан сонголтоор Дархан-144 сортын 3700 ш түрүү, Дархан-131 сортын 3800 ш түрүү, Дархан-166 сортын 3600 ш түрүү, Дархан-34 сортын 3100 ш түрүү буюу нийт **14200** ш түрүү сонгосон. |

- Бөөний сонголтоор дээрх сортуудын 331000 ширхэг түрүү буюу 398 кг үр сонгон авч элит үрийн эх материалын сонголтыг бий болгосон байна.

*Анхдагч үрийн аж ахуйг хөтлөн явуулах*

- Сонгосон түрүү удмуудыг үрийн аж ахуйн схемийн дагуу хийж гүйцэтгэжээ. Удмын үнэлгээний 1 дэхь жилийн талбарт лабораторийн үнэлгээ өгч Дархан-144 сортын 2962 ш бүл, Дархан-131 сортын 2319 ш бүл, Дархан-166 сортын 2054 ш бүл, Дархан-34 сортын 1200 ш бүл буюу сортын шинжийг хадгалсан нийт 8035 ш бүлийг бий болгосон.
- Удмын үнэлгээний 2 дахь жилд дээрх 4 сортын 2272 ш бүл буюу 710.2 кг үрийг бий болгож үржүүлгийн 2 дахь жилийн талбарт шилжүүлж элит үрийн эх материалыг баяжуулсан.
- Үржүүлгийн 1 дэх жилийн талбарт Дархан-144 сортын 1100 кг үр, Дархан-131 сортын 1125 кг үр, Дархан-166 сортын 1395 кг үр, Дархан-34 сортын 880 кг үр буюу нийт 4500 кг үр бий болгосон.
- Үржүүлгийн 2 дахь жилд Дархан 144 сортын 4.9 т үр, Дархан-131 сортын 3.8 т үр, Дархан-166 сортын 3.6 т үр, Дархан-34 сортын 2.8 т үр нийт **15.3 т** үр үйлдвэрлэсэн.

*Элит үр үйлдвэрлэл*

- Супер элит үр Дархан-144 сортын 15 т, Дархан-131 сортын 12.3 т, Дархан-166 сортын 12.3 т, Дархан-34 сортын 7.7 т үр буюу нийт 47.3 т-ийн тус тус үйлдвэрлэсэн.
- Элит үр Дархан-144 сортын 6 т үр, Дархан-131 сортын 5.3 т үр, Дархан-166 сортын 6.0 т үр, Дархан-34 сортын 7.7 т үр буюу нийт 22.5 т үр үйлдвэрлэсэн.

*Уриншийн боловсруулалт*

- Уриншийг 2014 онд 4.5 га, 2015 онд 26.5 га, 2016 онд 54 га буюу нийт төслийн хугацаанд 85 га талбайд уринш боловсруулан тариалалт хийсэн байна.

| Үр дүнгийн үзүүлэлтүүд | | 2014-2016 он | | |
|---|---|---|---|---|
| | | Төлөв-лөсөн | Гүйц-этгэл | Хувь |
| Үр үржүүлэг, селекцийн ажил хийх талбай, га | | 84.9 | 85 | 100 |
| Эх материалын сонголт | Ганцаарчилсан сонголт, мянган ширхэг | 12.0 | 13.2 | 100 |
| | Бөөний сонголт, мянган ширхэг | 300.0 | 331.0 | 100 |
| Анхдагч үрийн аж ахуйг хөтлөн явуулах | Удмын үнэлгээ - 1 /Бүл/ | 7500 | 8035 | 100 |
| | Удмын үнэлгээ - 2 /Бүл/ | 2250 | 2272 | 100 |
| | Үржүүлэг- 1 /т/ | 2.8 | 4.5 | 100 |
| | Үржүүлэг – 2 /т/ | 12.7 | 15.3 | 100 |
| Элит үр үйлдвэрлэл | Супер элит, /т/ | 42.2 | 47.3 | 100 |
| | Элит, /т/ | 16 | 22.5 | 100 |
| Дундаж | | | | 100 |

ХШҮ-100

Буудайн арвин ургацтай,

*Солонгос болон Монгол орны буудайн сорт дээж солилцох, сорих,*

| | | |
|---|---|---|
| | биохими технологийн чанар сайтай ган болон өвчинд тэсвэртэй селекцийн эх материал бий болгох<br>2-р зорилтын хүрээнд : | *селекцид ашиглах*<br>- БНСУ-аас өвөлжих буудайн 28 сортыг дугаарыг дээж судлахад 11, 22 дугаар эрт болцтой, 8, 12, 14, 15, 16, 18 дугаарууд болц гүйцсэн, 25, 17, 20, 28, 29, 19 дугаарууд алаг цоог боловсорсон бусад дугаарууд оройтож болц гүйцсэнгүй. Хяналт сортын ургац 23.92-48.99 г/м$^2$, судлагдсан сортууд 0.56-9.7 г/м$^2$ үр өглөө.<br>- Солонгос ба Монгол сортыг ашиглан 12 хослолоор 540 цэцэг засч 87 ширхэг эрлийз үр авсан. Үр тогтолтын амжилт 7.4-58.3% байсан.<br>- Монгол болон гадаадын шалгарсан сортуудыг хооронд нь 40 хослолоор эвцэлдүүлж 2116 ш эрлийз үр гарган селекцийн эх материалыг баяжуулсан.<br>*Буудайн бүтээгдэхүүншилт, чанар, ган, халуун тэсвэрийг сайжруулах селекци.*<br>- 40 хослолын $F_1$ удмыг гараар тарьж аж ахуйн биологийн ашигтай шинжээр үнэлж дэвсгээр хураах сөрөг сонголт хийлээ. Судалгаанд хамаарагдсан удмууд 67-84 хоногт болов-сорсон ба Дархан-131, CDC Go, Stettler, MK-261, HTWSN-88-13 сорт, дугааруудын эрлийз удмууд хамгийн эрт болцтой байлаа.<br>- $F_2$ удмаас нийт 39 хослолын 223 удмыг зохиомол, хээрийн нөхцөлд харьцуулан судлаж түрүүний бүтээмжийн бууралтаар 12 хослол шалгаруулан нийт 785 түрүүг сонголоо.<br>- Шалгарсан Yecoro Rojo x Дархан-131 хослолд уургийн агуулалтыг сайжруулдаг Gpc-B1 тэмдэгт ген ашиглан 30 түрүүг сонгосон.<br>*Буудайн селекцийн дугааруудад ургац, чанар, ган, халуун тэсвэрийн үнэлгээ өгөх, шалгаруулах*<br>- Төслийн хугацаанд селекцийн эрлийз болон мутант 40 дугааруудыг сонгон 2014 онд судлаж 20 дугаарыг дэвшүүлсэн.<br>- 2015 онд 20 дугаар судлаж 10 дугаарыг шалгаруулан мөн 2016 онд 10 дугаарыг 28 үзүүлэлтээр харьцуулан судалсан. Судалгааны дүнгээр дунд оройн болцтой Дархан-222 сорт жишиг Дархан-144 сортоос 3.5 ц/га ургацтай, уураг 13.3%, цавуулаг 29.5%-ийн цавуулгийн агуулалттай шалгарч байна.<br>- Буудайн зонхилох 6 зүйлийн өвчин тэсвэрийн үнэлгээгээр Дархан-214, Дархан-222 сортууд тэсвэртэй. Дархан-218 сорт өвчинд өртөмтгий буюу дунд зэрэг тэсвэртэй сорт байна.<br>*Шинэ сортыг үйлдвэрлэлд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ашиглах*<br>- 2014-2016 онд Монгол оронд тариалагддаг 24 сортыг цуглуулан адил хугацаанд нэг технологиор сорт тус бүрийг 50м$^2$ дэвсэгт 3 давталтаар тариалж үзүүлэх талбар байгуулсан.<br>- Судалгааны дүнгээр Монгол оронд тариалагдаж буй сортуудаас эртийн болцтой 5 сортоос Дархан-172 сорт хяналт Дархан-131 сортоос 1.8 ц/га нэмүү, дундын болцтой 14 сорт соригдс-ноос хяналт Дархан-34 сортоос Дархан-72, Алтайская-325, Алтайская-100, Алтайская-70 сортууд 2.0-7.6 ц/га илүү, дунд оройн болцтой 6 сорт соригдсоноос хяналт Дархан-144 сортоос Дархан-181 сорт 1.9 ц/га ургац-аар илүү байж шалгарсан байна.<br>*Талбайн сургалт*<br>Уг талбарт сортуудыг харьцуулан судлахаас гадна тариаланчдад сорт, үрийн ач холбогдол, сорт сонгоход зориулан сургалт, |

талбайн өдөрлөгүүдийг зохион байгуулжээ.

- “Улаан буудайн үр үржүүлэг” сэдэвт, сургалт талбайн өдөрлөг 80 гаруй тариаланчид оролцсон. /19.08.2014/
- “Үр тариа болон буурцагт таримлын сорт судалгаа, үр үржүүлэг” сэдэвт сургалт талбайн өдөрлөгт 100 тариаланчид оролцсон. /28.07.2016/

*Семинар*

- “Улаан буудай тариалалтын өнөөгийн байдал болон хөгжлийн чиг хандлага” семинарт 4 аймгийн 50 тариаланчид оролцсон /2014.10.23/
- “Үр тарианы сорт, үр үйлдвэрлэл эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн бага хурал” сэдэвт семинарт 53 аж ахуй нэгжийн 90 гаруй тариаланчид хамрагдсан /06.11.2015/

*Хэвлүүлсэн ном, гарын авлага*

- Улаан буудай тариалалтын өнөөгийн байдал болон хөгжлийн чиг хандлага” семинарын эмхтгэл, 2014.10.23
- Үр тарианы сорт, үр үйлдвэрлэл эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн бага хурлын эмхэтгэл, 2015
- Үрийн тариалангийн технологи нутагшсан сортууд, 2015
- Буудайн зонхилох өвчин, тэсвэртэй сортууд, 2016

| Үр дүнгийн үзүүлэлтүүд | 2014-2016 он | | |
|---|---|---|---|
| | Төлөв-лөсөн | Гүйц-этгэл | Хувь |
| Солонгос болон Монгол буудайн сорт дээж солилцох,сорих, селекцид ашиглах | 40 | 40 хослол | 100 |
| Буудайн бүтээгдэхүүншилт, чанар, ган, халуун тэсвэрийг сайжруулсан удам сонгох | 10-15 % | 12 | 100 |
| Стандарт сортоос 10-15% нэмүү ургацтай сорт шалгаруулах | 10-15% | 11,8% | 100 |
| 28 хувиас дээш цавуулагтай | 28 % | 29,5% | 100 |
| Үзүүлэх талбар байгуулах /10-15 сортоор/ | 10-15 | 24 | 100 |
| Талбайн сургалт, семинар зохион байгуулах | 2 | 4 | 100 |
| Монгол оронд нутагшсан буудайн 4 сортын элит үр гаргах | 4 | 4 | 100 |
| Тариаланчдын нэг га-аас хураан авах ургац | 15-20 хувь | - | ҮБ |
| Дундаж | | | 100 |

ХШҮ-100

| | | |
|---|---|---|
| 7 | Дүгнэлт<br>(ололт, дутагдал, анхаарах асуудлууд) | Монгол улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны ХААҮШУОНТ болон Бүгд найрамдах Солонгос улсын Копиа-Монгол төвийн хооронд 2014-2017 онд хэрэгжих “Буудайн элит үр гаргах, үр үржүүлэх төсөл”-ийн ерөнхий үнэлгээ 100 хувьтай буюу “хангалттай сайн” үнэлэгдлээ.<br>Төслийн нийт санхүүжилт 165000 ам доллар батлагдсанаас 2014 онд 75000 ам доллар, 2015 онд 45000 ам доллар, 2016 онд 45000 ам доллар буюу нийт 165000 ам доллар төлөвлөн зарцуулж 100 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>Удирдлага, зохион байгуулалтын хувьд мэргэжлийн зүгээс хангалттай, тайлангийн чанар сайн байна.<br>➢ 1-р зорилтын үр дүнг илтгэх шалгуур үзүүлэлтийн |

<table>
<tr><td></td><td></td><td colspan="4">гүйцэтгэл 100 хувьтай үнэлэгдсэн.<br>➢ 2-р зорилтын үр дүнг илтгэх шалгуур үзүүлэлтүүдийн гүйцэтгэл 100 үнэлэгдсэн байна. Шинэ сортыг 3 жилийн дотор гаргах боломжгүй. Эрлийз удмуудыг судлаад Дархан 222 дугаар нь стандарт сортоос 3.5 ц/га ургацтай, 29.5% цавуулагтай, зонхилох өвчинд тэсвэртэй гэж шалгарсан нь цаашид шинэ сорт болох магадлалтай байна.<br>Төслийн баримт бичиг ойлгомжтой, тодорхой боловсруулагдаж, 2014-2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, биелэлт хангалттай сайн үнэлэгдлээ.</td></tr>
<tr><td>8</td><td>Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ</td><td colspan="4">Төслийг хэрэгжүүлэгч талууд бололцоо, нөөцөө дайчлан хамтын ажиллагааг зохих түвшинд хэрэгжүүлж ажилласан.</td></tr>
<tr><td rowspan="2">9</td><td rowspan="2">Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ)</td><td>Биелэлт дундаж</td><td>Зорилтын тоо</td><td>Зорилт 1</td><td>Зорилт 2</td></tr>
<tr><td>100</td><td>2</td><td>100</td><td>100</td></tr>
<tr><td rowspan="2">1<br>0</td><td rowspan="2">Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)</td><td colspan="2"></td><td colspan="2">Нэгдсэн үнэлгээ</td></tr>
<tr><td colspan="2"></td><td colspan="2">...%</td></tr>
</table>